



УВААГ

Óāñ àéí àèéí Àóàèòú í àāçàð

**ÓĀÑ ÀÈÌ ÆÈÉÍ Õª ÑĀÈÉÍ
ЕРӨНХИЙЛӨН ÇÀÕÈÐĀĀx**

**2013 Î Í Û САНХҮҮГИЙН
Í ÝÃÒÃÝÑÝÍ ÒÀÉËÀÍ**

Аудитыг дуусвар болгосон тухай тайлан

АГУУЛГА

ХУУДАС

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараахь хаягаар харилцана уу:**
Тэргүүлэх àóāèòí ð: Ë.Āàò-Ī ÷èð
Утас: 70453317

Аудитын менежер: С.Батжаргал
Утас: 70453721

Аудитор: Т.Намжил
Утас: 70453721

Àéí æèéí аудитын газар

ÀçĀÒĀ-úí байр
Óèāáí ā í ñóí
Óāñ àéí àā
Монгол Улс

Оршил
Санхүүгийн дотоод хяналтын үнэлгээ
Аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан
шийдлүүд
Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
Аудитын санал дүгнэлт

Хавсралт 1: Менежментийн захидал

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Аудитлагдсан санхүүгийн тайлан

2014 оны 04-р сарын 18

ÓĀĀĀГ-/2014/ -СТА

Оршил

Увс аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2013 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудит дууссан тул энэхүү тайланг аймгийн Засаг даргад танилцуулж байна.

Төсвийн тухай хуулийн 8.9.4-д “Аймаг, нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагч жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг жил бүрийн 4 дүгээр сарын 01-ний дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлнэ” гэж заасан байхад аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг 2014 оны 04 сарын 08-нд ирүүлэн хуулийн хугацааг ажлын 5 өдрөөр хэтрүүлсэн нь санхүүгийн аудит хийх цаг хугацаанд сөргөөр нөлөөлж хүндрэл учруулсан болно.

Санхүүгийн дотоод хяналтын үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс санхүүгийн хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Ийнхүү дахин хянахдаа Орон нутгийн төсвийн байгууллагуудын хяналтыг санхүүгийн эрсдэл ба хяналтын талаархи өөрийн мэдээллийн сантай харьцуулан шинжилгээ хийсэн юм.

Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах боломж олгосон. Тухайн жилд асуудал үүсгэсэн тэдгээр хяналтыг бид аймгийн Засаг даргад тайлагнаж байна.

Бидний олж илрүүлсэн дараах асуудлын чиглэлд хяналтыг илүү сайжруулах шаардлагатай байна.

Аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд

Орон нутгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн нэгтгэсэн санхүүгийн тайланд аймгийн 65 Орон нутгийн төсөвт байгууллага, 19 сумын төрийн сан, 13 төсөл сан, нийт 97 тайлан хамрагдлаа.

I. Орон нутгийн төсөвт байгууллагууд

II. Аймаг, сумын Төрийн сан

III. Төсөл, сан

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийг хураангуйлан гол асуудлуудыг дараах заалтад тэмдэглэв. Үүнд:

Нàí ò¿¿æéí òàéèàí æéí àóäèòààð í èèò 3 албан шаардлагаар 1.5 сая төгрөгийн албан шаардлага тогтоож, 31 актаар 361.4 ñàÿ ò° äð° æéí àèò òì ääí î æ 5109.3 ñàÿ ò° äð° æéí àèààà ç° ð÷èè èèð¿¿èñí ýñ 4791.8 ñàÿ ò° äð° æéí àèàààà санхүүгийн тайланд çàèðóóèèàà.

Орон нутгийн төсөвт байгууллагууд:

Залруулсан алдаа: Дараах зөрчлүүдийг санхүүгийн тайланд залрууллаа.

- Хяргас сумын ИТХ 1808.2 мянган төгрөгөөр орлогыг илүү, аймгийн ИТХ, Худалдан авах ажиллагааны алба, Малчин, Тариалан, Сагил, Наранбулаг, Өмнөговь, Тэс, Бөхмөрөн сумдын ЗДТГ, Зүүнхангай, Өмнөговь, Тэс сумын ИТХ, Малчин, Тэс сумын баг нийт 14 байгууллага 528663.6 мянган төгрөгийн орлого дутуу тайлагнасан.
- Худалдан авах ажиллагааны алба, Хяргас сумын ЗДТГ, ИТХ, Баг, Давст сумын Баг, Бөхмөрөн сумын ЗДТГ нийт 37015.7 мянган төгрөгөөр зардлыг дутуу илэрхийлсэн байна.
- Ахмадын хороо, Түргэн, Өндөрхангай сумын Ойн анги, Улаангом, Малчин, Зүүнхангай, Завхан сумдын ЗДТГ, Улаангом сумын Баг, Малчин сумын ИТХ нийт 8 байгууллага 3420.3 мянган төгрөгийн зардлыг буруу ангилж тайлагнажээ.
- Аймгийн ЗДТГ, Хяргас, Тэс сумын ЗДТГ, Баруунтуруун сумын ЗДТГ, ИТХ, Баг нийт 6 байгууллага 339869.1 мянган төгрөгийн авлага, Бөхмөрөн сумын ЗДТГ 27617.9 мянган төгрөгийн өглөгийг санхүүгийн тайланд тусгаагүй байна.
- Худалдан авах ажиллагааны алба, Зүүнхангай, Тариалан, Завхан, Өлгий, Баруунтуруун, Бөхмөрөн сумдын ЗДТГ, Өмнөговь, Баруунтуруун сумын Баг, нийт 9 байгууллага 182937.5 мянган төгрөгийн хөрөнгө, материалыг бүртгэлд тусгаагүй, буруу илэрхийлсэн.
- Наранбулаг сумын ЗДТГ 216500.0 мянга, Өлгий ЗДТГ 158800.0 мянга, Давст ЗДТГ 119264.4 мянга, Давст сумын ИТХ 13760.0 мянга, нийт 508324.4 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилтийг Төсвийн гүйцэтгэлийн тайланд тусгаж төсвийн гүйцэтгэлийг буруу илэрхийлсэн байна.
- Баруунтуруун сумын ЗДТГ, ИТХ, Бөхмөрөн сумын ЗДТГ, ИТХ, Баг нийт 5 байгууллага 249723.3 мянган төгрөгөөр дахин үнэлгээний зөрүүг буруу илэрхийлсэн.
- Бөхмөрөн сумын ИТХ 158.5 мянга, Баг 438.5 мянга, нийт 597.0 мянган төгрөгөөр санхүүгийн байдлын тайланд тайлант үеийн үр дүнг буруу илэрхийлсэн.
- Бөхмөрөн сумын ЗДТГ нэмэлт санхүүжилтийн дансны үлдэгдэл 3000.0 мянган төгрөгийг санхүүгийн тайланд тусгаагүй байсныг залрууллаа.

Залруулаагүй алдаа: Дараах зөрчлүүдийг санхүүгийн тайланд залруулах боломжгүй байна.

- Аймгийн ЗДТГ, ИТХ, Худалдан авах ажиллагааны алба, Орон нутгийн өмчийн алба, Мал эмнэлгийн алба, Ахмадын хороо, Өндөрхангай сумын Ойн анги, Улаангом, Малчин, Сагил, Өндөрхангай, Наранбулаг, Ховд, Хяргас, Түргэн, Өлгий, Зүүнговь, Давст, Цагаанхайрхан, Бөхмөрөн сумдын ЗДТГ, ИТХ, Баг, Зүүнхангай сумын ЗДТГ, Баг, Завхан, Өмнөговь сумын ЗДТГ, ИТХ, Баруунтуруун сумын ЗДТГ, нийт 51 байгууллага 153224.5 мянган төгрөгийн батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна.
- Орон нутгийн хөгжлийн сангаас аймгийн ИТХ 7896.8 мянга, Улаангом сумын ЗДТГ 18442.0 мянга, Малчин сумын ИТХ 9999.9 мянга, Завхан сумын ЗДТГ 8040.0 мянга, Зүүнговь сумын ИТХ 20000.0 мянга, Тэс сумын ИТХ 20000.0 мянга, Цагаанхайрхан сумын ИТХ 14800.0 мянга, нийт 7

байгууллага 99178.7 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.

- Улаангом сумын ИТХ 1022.4 мянга, Өндөрхангай сумын ЗДТГ 129.0 мянга, Бөхмөрөн сумын ИТХ 1700.0 мянга, Бөхмөрөн сумын ЗДТГ 16765.1 мянга, нийт 19616.5 мянган төгрөгийг ажил гүйлгээг нотлох ага өгөгдөл байна.
- Өндөрхангай сумын ЗДТГ 90.1 мянга, Ховд сумын ЗДТГ 492.4 мянга, Хяргас сумын ИТХ 354.8 мянга, нийт 937.3 мянган төгрөгийн цалин, урамшууллыг олгохдоо хууль тогтоомжийг зөрчиж илүү олгосон байна.
- Орон нутгийн өмчийн алба 310.0 мянга, Баруунтуруун сумын ЗДТГ 2000.0 мянга, Бөхмөрөн сумын ИТХ 4295.7 мянга нийт 6605.7 мянган төгрөгийн өглөгийг санхүүгийн тайланд тусгаагүй байна.
- Аймгийн ЗДТГ, Малчин, Цагаанхайрхан, Завхан, Бөхмөрөн сумын ЗДТГ, Өлгий сумын ИТХ нийт 6 байгууллага 4118.2 мянган төгрөгийн татвар шимтгэл дутуу суутгасан байна.
- Өлгий сумын ЗДТГ 1900.0 мянга, ИТХ 800.0 мянга, Баг 900.0 мянга, нийт 3600.0 мянган төгрөгийн цалингийн зардлаас хуулинд заагдаагүй суутгал хийсэн байна.
- Хууль тогтоомжийг зөрчиж Сагил сумын ЗДТГ 80.8 мянга, Өндөрхангай сумын ЗДТГ 218.2 мянга, Давст сумын ЗДТГ 214.8 мянга, Цагаанхайрхан сумын ЗДТГ 958.0 мянга, Бөхмөрөн сумын ЗДТГ 2411.4 мянга, нийт 3883.2 мянган төгрөгийн Төрийн захиргааны албан хаагчид хавсран ажилласны нэмэгдэл цалин олгосон байна.

Аймаг, сумын Төрийн сан:

Залруулсан алдаа: *Дараах зөрчлүүдийг санхүүгийн тайланд залрууллаа.*

- Зүүнговь сумын Төрийн сан 538.5 мянган төгрөгийн орлогыг илүү, Өндөрхангай сумын төрийн сан 15168.8 мянга, Ховд сумын Төрийн сан 190.0 мянга, Зүүнговь сумын Төрийн сан 4645.0 мянга, Давст сумын Төрийн сан 31538.4 мянга, нийт 51542.2 мянган төгрөгийн орлогыг санхүүгийн тайланд дутуу тайлагнасан.
- Завхан сумын Төрийн сан 4295.5 мянга, Малчин сумын Төрийн сан 3469.6 мянга, Цагаанхайрхан сумын Төрийн сан 165867.2 мянга, нийт 173632.3 мянган төгрөгөөр зардлыг дутуу тайлагнасан, Тариалан сумын Төрийн сан 58735.9 мянга, Цагаанхайрхан сумын Төрийн сан 2409.7 мянга, нийт 61145.6 мянган төгрөгөөр зардлыг илүү илэрхийлсэн.
- Зүүнговь сумын Төрийн сан 870.0 мянган төгрөгийн зардлыг буруу ангилж тайлагнажээ.
- Ховд сумын Төрийн сан 227.2 мянга, Хяргас сумын Төрийн сан 1000.0 мянга, Өмнөговь сумын Төрийн сан 11720.0 мянга, нийт 12947.2 мянган төгрөгийн авлага, Бөхмөрөн сумын Төрийн сан 25920.7 мянган төгрөгийн өглөгийг санхүүгийн тайланд тусгаагүй.
- Завхан сумын Төрийн сан 128917.0 мянга, Хяргас сумын Төрийн сан 2500.0 мянга, Өмнөговь сумын Төрийн сан 139617.7 мянга, нийт 271034.7 мянган төгрөгийн хөрөнгийг бүртгэлд тусгаагүй, данс бүртгэлд буруу илэрхийлсэн байна.
- Наранбулаг сумын Төрийн сан 266300.0 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилтийг Төсвийн гүйцэтгэлийн тайланд орлогоор тусгасан.

- Зүүнхангай сумын Төрийн сан 2020831.4 мянган төгрөгөөр санхүүгийн байдлын тайлангийн эхний үлдэглийг илүү илэрхийлсэн.
- Сагил сумын Төрийн сан 5390.4 мянган төгрөгийн Хүүхдийн цэцэрлэгийн дуусаагүй барилгыг дансанд шилжүүлэхдээ үнэ төлбөргүй хүлээн авсан орлогоор буруу бүртгэсэн.
- Өндөрхангай сумын Төрийн сан 813.0 мянган төгрөгийн хөрөнгийн хөдлөл, эрхийн орлогыг буруу тайлагнасан байна.
- Хяргас сумын Төрийн сан өмчийн өөрчлөлтийн тайланд тайлант үеийн үр дүнг 17725.8 мянган төгрөгөөр буруу илэрхийлсэнийг тус тус санхүүгийн тайланд залрууллаа.

Залруулаагүй алдаа: *Дараах зөрчлүүдийг санхүүгийн тайланд залруулах боломжгүй байна.*

- Í ðí í í óòæéí ð° ñâèéí òàòâàððûí áí èí í òàòâàððûí áóñ í ðèí ãû ãí èèò 6060.6 ñàÿ ð° æ° æ° ð òàéèàã àñàí í ü àéí æéí Òàòâàððûí öÿèòñÿÿñ æðãàñàí òàòâàððûí í ðèí ãûí ãÿéóÿòãÿéóÿé òààð÷ ààéí à. Òàðèí òàòâàððûí í ðèí ãûí í ÿð ð° ðè° ð í ü àâ÷ ÿÿáÿé òàèèí ð° èñ òÿÿí òÿé ààèèòãã ð ðèí ãûí òàòâàðð, ì àè áÿðèé èðãÿí èé í ðèí ãûí òàòâàððààñ áóñàà òàòâàððóóãûí ãÿéóÿòãÿé ÿ° ðÿÿóÿé ààéí à.
- Хяргас сумын Төрийн сан 500.0 мянган төгрөгийг ажил гүйлгээг нотлох анхан шатны баримтгүй зарцуулсан байна.
- Тариалан сумын Төрийн сан 3720.0 мянга, Зүүнговь сумын Төрийн сан 6843.6, нийт 10563.6 мянган төгрөгийн сум хөгжүүлэх сангаас олгосон зээлийн эргэн төлөлтийн хугацаа хэтэрсэн байна.
- Орон нутгийн хөгжлийн сангаас байгууллагын дансаар дамжуулахгүйгээр шууд бэлтгэн нийлүүлэгчид олгосон 8280.0 мянган төгрөгийн хөрөнгийг Өмнөговь сумын Төрийн сан байгууллагад үнэ төлбөргүй орлогоор бүртгэсэн байна.

Төсөл, сангууд:

Залруулаагүй алдаа: *: Дараах зөрчлүүдийг санхүүгийн тайланд залруулах боломжгүй байна.*

- Засгийн газрын 2010 оны 271 тоот тогтоолоор “Үндэсний их баяр наадмын арга хэмжээнд зориулан төсвөөс гаргах санхүүжилтийн жишиг дээд хэмжээг аймагт 10.0 (арван) сая төгрөг, суманд 5.0 (таван) сая төгрөг байхаар тус тус тогтоосугай” гэж заасныг зөрчин *аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас* баяр наадамд 29000.0 мянган төгрөг зарцуулж батлагдсан төсвийг 19000.0 мянган төгрөгөөр, Сагил сум 1000.0 мянга, Наранбулаг сум 1000.0 мянга, Тэс сум 1000.0 мянга, Давст сум 2000.0 мянга, Цагаанхайрхан сум 2000.0, нийт 26000.0 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулжээ.
- Засгийн газрын 2013 оны 03 сарын 68 тоот тогтоолоор Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд мөрдөх журмыг сонгоход баримтлах босго үнийг тогтоосныг зөрчиж ажиллажээ. Аймгийн ИТХ-ын төлөөлөгчдийн I-рад нийлүүлэхэд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8.2-д “Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ

хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ” гэж заасныг зөрчсөн байна.

- Аймгийн ИТХ-ын парк шинчлэлийн 139000.0 мянган төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангаас бэлтгэн нийлүүлэгч Д.Алтангэрэлийн хувийн харилцах дансанд шилжүүлэн өгсөн нь ХХОАТ-ыг хэрхэн тооцсон нь тодорхойгүй байна.

Дээрх ашиггүй үйлдлийг зогсооход өргөтгөлийн үйлдлийн талаархи санал бодол, менежментийн захидалтай нийлээд аудитаар илрүүлсэн гол зүйлсийг бүрдүүлж өгнө.

Аудитын санал дүгнэлт

Бид Өмнөд зүгээр өргөтгөлийн ерөнхийлөн захирагчийн 2013 жилд нэгтгэсэн санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүн, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээийн талаарх Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УНТ, АТ, ОН, НТ, өргөтгөлийн үйлдлийн талаарх санал бодол, менежментийн захидалтай нийлээд аудитаар илэрхийлсэн зүйлсийг **Зөрчилгүй** санал дүгнэлт өгөхийг Ерөнхий Аудитор санал болгож байна.

Өмнөд зүгээр өргөтгөлийн захирагч

2014 оны 4 дүгээр сарын 18